

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ,  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ  
/2015 оны эхний хагас жилийн байдлаар/

2015 оны 06 дугаар сарын 19

Үйлдвэр хөдөө аж ахуйн газар

№	Эрх зүйн Актын нэр он, сар, дугаар	Заалт	Хэрэгжүүлэх гарсан шийдвэр, төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл /Хувь/	Үр нөлөө
<b>НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ</b>					
<b>1</b>	“Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратеги баримт бичиг”-ийг батлах тухай 2015.04.30 № 26/08	2.1 Стратеги баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах	-Хэлтсүүдээс санал авна -Саналыг НЭЗХГ-т хүргүүлнэ -Төлөвлөгөө батлуулна	“Улаанбаатар хотын эдийн засгийн стратеги” баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн салбарын хүрээнд тусгах арга хэмжээний саналыг боловсруулж, 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 04/218 дугаар албан бичгээр НЭЗХГ-т хүргүүлэв.  70%	Нэгдсэн төлөвлөгөөнд салбарын чиг хандлагыг бодитой тусгана
		2.2 Стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, нийслэлийн төсөвт тусгах, хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулах, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах	- Төсвийн тооцоо хийнэ - Шаардлагатай хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт суулгах санал хүргүүлнэ	Стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн судалгааг гаргаж, улс, нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төсөв, төсөлд саналаа хүргүүлэхээр ажиллаж байна.  10%	Баримт бичигт тусгагдсан ажлууд хэрэгжинэ
		2.3 Стратеги баримт бичгийн биелэлтийг жил бүр гаргаж НИТХ-д танилцуулах	-Тайланг нэгтгэнэ -Тайланг хүргүүлнэ	Стратеги баримт бичгийн биелэлтийг холбогдох хэлтсүүдээс авч, нэгтгэн НИТХ-д танилцуулна. Хугацаа болоогүй.  0%	Бодлого, зорилт үе шаттай хэрэгжиж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.
<b>2</b>	“Нийслэл орчмын	2. Нийслэл орчмын бэлчээрийн	Хөтөлбөрийг	- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөрөнгө	Хот орчмын бүсэд

	<p>бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлах тухай” 2015.02.17 № 32</p>	<p>менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг авч, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.</p>	<p>хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах захирамж гаргуулж, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>оруулалтын ажилд 2.8 тэрбум төгрөг, урсгал зардалд 197.0 сая төгрөгийг тус тус нийслэлийн 2015 оны төсөвт тусгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, 2015 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.</li> <li>- Хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэх зорилгоор хөтөлбөрийн хүрээнд худалданавахажиллагаазохионбайгуулахэрхшил жүүлэхзахирамжийн төсөл,тооцоо судалгааг НЗДТГ-ын СБТХ-т хүргүүлээд байна.</li> <li>- Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламж барих тендерийн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг байгуулан Тендерийн баримт бичгийг боловсруулаад байна.</li> <li>- НИТХТ-ийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх Зүүн хадатын амны байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан Сонгинохайрхан дүүргийн Өмч, газрын харилцааны алба болон хорооны Засаг даргатай зөвшилцсөнөөр Сүмбэр хайрханы зүүн хойд талын Өвөр шар хоолойн амыг сонгосон. Уг байршил дээр тусгай хэрэгцээнд авах 962.57 га талбайн кадастрын зураг, барилгажих 2.0 га-гийн кадастрын болон дэвсгэр зураг, тариалалт хийх 150.0 га-гийн кадастрын зургийг хийлгэн Сонгинохайрхан дүүрэгт хүргүүлээд байна.</li> <li>- Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Улиастайн голын эх” байгалийн</li> </ul>	<p>мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлж, хөрс цаг уурын нөхцөлд тохирсон ургах чадвар бүхий тэжээллэг ургамлыг нутагшуулснаар бэлчээрийн менежментийг шинэчилж, цөлжилтийг бууруулна.</p>
--	---	---	---	--	--

				<p>цогцолбор газрын аялал жуулчлалын болон хязгаарлалтын бүсэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан НБОНХГазарт хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/480 дугаар захирамжаар НЗД-ын орлогч Т.Бат-Эрдэнэ, НҮХААГ-ын дарга Г.Пүрэвсүрэн, НҮХААГ-ын Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, НЗДТГ-ын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Р.Эрдэнэ нар нарийвчилсан төлөвлөгөө, санхүүжилтийг эцэслэн шийдвэрлэхээр Бүгд найрамдах Австри улсад 06 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллалаа.</p> <p>50%</p>	
3	Журам батлах тухай 2015.05.15 № 85	2. “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ын талаар нийслэлийн нутаг дэсгэрт мал аж ахуй эрхлэж байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад танилцуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн жил бүрийн үндсэн чиглэлд тусган ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч/Э.Бат-Үүл/-д даалгасугай	Нийслэлд мал аж ахуй эрхлэх журмын дагуу 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	2015 онд 2 зорилт 16 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөг боловсруулан, газрын даргаар батлуулаад байна. Дараах ажлыг хийж гүйцэтгэлээ: - Чингэлтэй дүүргээс 345 толгой мал зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлээд байна. - Баянгол дүүргийн малыг бүрэн гаргалаа. - Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн хориглосон бүсийн хороодод байгаа малыг шилжүүлэх тухай Засаг даргын захирамжийг гаргуулаад байна. - Сонгинохайрхан дүүргийн 17 хорооны хориглосон бүсэд байгаа 56107 толгой малыг зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлэх газрыг шийдвэрлэсэн байна. 50%	Эрүүл аюулгүй орчин бүрдэж эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэнэ.
4	“Монгол мал” дэд хөтөлбөр батлах тухай 2014.07.08 № 119	2. Нийслэлийн “Монгол мал” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж нийслэлд мал аж ахуй эрхлэх болон хориглосон бүс нутгийн талаар нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэж байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад танилцуулж,	- “Монгол мал” дэд хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэх 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	2015 онд хөтөлбөр хэрэгжүүлэхээр 4 зорилт бүхий 31 ажлыг төлөвлөөд байна. Дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: - Тэжээл дэд хөтөлбөрийн төслийг боловсрууллаа. - Нийслэлийн мал бүхий дүүргүүдэд зохиомол хээлтүүлгийн явуулын 6 техникч, үржлийн 1 хоршоо ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 5 аж	Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуйг бүрэн цогцолбор байдлаар хөгжүүлэх боломжтой болно

		<p>хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Э.Бат-Үүл/-д хэрэгжитэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>ахуй нэгж, 30 иргэний нийт 60 гаруй үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн байна. Мөн энэ ажлын хүрээнд зохиомол хээлтүүлгийн захиалга, үйлчилгээ, малын нөхөн үржихүйн талаарх мэдээ мэдээллийг бэлтгэн байгууллагын веб сайтан дээр нийтэллээ.</p> <p>- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Багануур, Багахангай, Налайх, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд шинээр гаргах худгийн байршил тогтоож, НЗД-ын 2015 оны А/293 дугаар захирамжийн дагуу гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;">50%</p>	
		<p>3. Нийслэлд “Монгол мал” дэд хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн жил бүрийн үндсэн чиглэлд тусгахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.</p>	<p>-</p>	<p>“Монгол мал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн малыг 2015-2021 онуудад бүртгэлжүүлэхэд шаардагдах төсвийн тооцоог 3.8 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр боловсруулан Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-ийн төслийн багт холбогдох материалын хамт хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Пост, захуудын байршлыг тогтоож, сүлжээний программд холбох нөхцлийг судлан, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа, тооцоог гаргаж, нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай төсвийн саналыг тусган СБТГ-т хүргүүлээд байна.</p> <p>Мөн Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээний санал, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтод тусгах ажлын санал, 2016 онд Нийслэл, улсын төсвөөс хийгдэх хөрөнгө оруулалтын санал, ХЗЯ-ны малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгах саналуудад уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын саналыг боловсруулан холбогдох газруудад</p>	

				хүргүүлээ. 50%	
5	Нийслэлийн тэргүүний фермерийг шалгаруулах журам	2014.12.15 №221	- Хөрөнгө гаргах тухай Нийслэлийн засаг даргын захирамж гаргуулах - Ёслолын ажиллагааг зохион байгуулах	“Нийслэлийн тэргүүний фермер”-ээр шалгарсан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны фермер Д.Шаравнямбуу, Б.Мандах, Хан-Уул дүүргийн 13, 14 дүгээр хорооны фермер Х.Ганхуяг, Б.Батмагнай, Налайх дүүргийн 2 дугаар хорооны фермер Т.Чулуунгэрэл, Багануур дүүргийн 2, 4 дүгээр хорооны фермер Т.Баярсайхан, Ш.Батсайхан, Д.Дашрэнцэндорж, “Хишигтэн нүүдэлчин” ХХК, “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгарсан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны “Сөөсгөр” ХХК, Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны “Сэвсүүл ногоон бүрд” ХХК, “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгарсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны тариаланч Б.Одончулуун, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны тариаланч Ж.Наранцэцэг нарын өргөмжлөл, дурсгалын зүйл, энгэрийн тэмдэг, мөнгөн шагналд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас гаргах тухай Нийслэлийн Засаг даргын А/138 дугаар захирамж гарч, шагналыг 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн удирдлагууд гардууллаа. 100%	Салбарт ажиллах иргэдийн идэвх санаачилга нэмэгдэнэ
6	Нийслэлийн сайн малчин шалгаруулах журам	2014.12.15 №222	- Хөрөнгө гаргах тухай Нийслэлийн засаг даргын захирамж гаргуулах - Ёслолын ажиллагааг зохион байгуулах	“Нийслэлийн сайн малчин”-аар шалгарсан Багануур дүүргийн 2 дугаар хорооны малчин Ж.Баттулга, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны малчин Д.Жамъяншарав, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны малчин Д.Алтангэрэл нарын өргөмжлөл, дурсгалын зүйл, энгэрийн тэмдэг, мөнгөн шагналд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас гаргах тухай Нийслэлийн Засаг даргын А/138 дугаар захирамж гарч, шагналыг 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн удирдлагууд гардууллаа.	Салбарт ажиллах иргэдийн идэвх санаачилга нэмэгдэнэ

				100%	
--	--	--	--	------	--